

Н.Б.С.



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 120

Даланзадгад

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "ж", 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эх үүсвэрийг жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон жил бүрийн эцэст аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Х.СУГИР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
05-ны өдрийн 120 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" хөтөлбөр

Нэг.Нийтлэг үндэслэл

Өмнөговь аймаг 2017 оны эцсийн байдлаар 65645 хүн амтай, үүнээс 49,8 хувь нь буюу 32659 нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Хүн амын хөдөлмөрийн насны /15-59 нас/ 41691 иргэдийн 49,3 хувь буюу 20537 нь эмэгтэйчүүд, 0-14 насны 20103 хүүхдийн 48,9 хувь нь буюу 9836 нь эмэгтэй хүүхэд, тэтгэврийн насны 3851 иргэн байгаагаас 2286 нь буюу 59,3 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэхүү тоон үзүүлэлтээс харахад хөдөлмөрийн насны иргэд, 0-14 насны хүүхдийн хүйс харьцангуй тэнцвэртэй байгаа бол тэтгэврийн насны иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

Төрийн албан хаагчид 3628 байгаагаас 2520 буюу 69,4 хувь нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд нийт 86 улс төрийн албан тушаалтан байгаагаас 13 /15%/, 49 захиргааны албан тушаалтнаас 22 нь /44,8%/, 9 тусгай албан тушаалтнаас 4 нь эмэгтэйчүүд эзэлж байгаа бол үйлчилгээний удирдах албан тушаалтан 133-аас 89 нь буюу 66,9 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг илтгэж байгаа юм.

Өмнөговь аймгийн иргэдийн дундаж наслалт 71,8, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67,7, эмэгтэйчүүдийнх 76,4 байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 308 нас баралт бүртгэгдсэнээс 63,5 хувь нь эрэгтэйчүүд эзэлж байна.

Уул уурхайн салбарт ажиллаж байгаа 3275 иргэнээс 919 нь /28%/, эмэгтэй, боловсролын салбарт ажиллаж байгаа 2329 иргэнээс 2026 /86,9%/, хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй 8640 ажиллагсдын 3561 /41,2%/, нь эмэгтэйчүүд байна. Салбар бүрт ажиллаж буй ажиллагсдын хүйсийн ялгавартай байдал их байгаа нь харагдаж байна.

Дээрх статистик тоон мэдээллүүд болон төрийн бус байгууллагаас хийсэн Өмнөговь аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг талаарх нөхцөл байдлын дүн шинжилгээний дүгнэлтээс харахад аймгийн хэмжээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг /Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоол/ хэрэгжүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох, нийгэм, эдийн засгийн үр шимийг эрх тэгш хүртэх боломжийг сайжруулах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг орон нутгийн онцлогт тохирсон нэгдсэн бодлого, зохицуулалт шаардлагатай байгаа юм.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Зорилго: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах, хүйсийн эрх тэгш оролцоог салбар бүрт нэмэгдүүлэх, жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх нөхцлийг бий болгоход чиглэгдэнэ.

Зорилт:

1. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх, жендэрийн судалгаа, үнэлгээг салбар бүрээр хийх
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг зохион байгуулах мэргэжилтэн боловсон хүчнийг чадавхжуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах
3. Олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

- ✓ Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Жендэр болон жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах

Үр дүн:

- ✓ Олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг ойлголт сайжирсан байна
- ✓ Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрсэн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдээлэл, сурталчилгаа, нэвтрүүлгийн тоо нэмэгдсэн байна.

“Нийгмийн хөгжлөөс эрэгтэй эмэгтэй хүн эрх тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” 4 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн туламж үйлчилгээг өргөжүүлэх, эрэгтэйчүүдийн кабинетийн үйлчилгээг сайжруулан, тогтмолжуулах
- Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах
- Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах
- Шийдвэр гаргах түвшинд дэх хүйсийн харьцааг нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах арга хэмжээ зохион байгуулах

Үр дүн:

- ✓ Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нэмэгдэнэ.
- ✓ Эрэгтэйчүүдийн кабинетийн үйл ажиллагаа тогтмолжиж, үйлчилгээ өргөжсөн байна
- ✓ Хүчирхийллээс хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвтэй болсон байна
- ✓ Иргэд олон нийт жендэрт суурилсан аливаа ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголттой болсон байна.
- ✓ Шийдвэр гаргах түвшний хүйсийн зохистой харьцаа нэмэгдсэн байна.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

- 5.1. Улсын төсөв
- 5.2. Орон нутгийн төсөв
- 5.3. Олон улсын байгууллагын хандив, төсөл хөтөлбөр
- 5.4. Бусад эх үүсвэр

4. Нийгмийн хөгжлөөс эрэгтэй эмэгтэй хүн эрх тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх

Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

“Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх, жендэрийн судалгаа, үнэлгээг салбар бүрээр хийх” 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Сумдын жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах мэргэжил арга зүйгээр хангах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах /хяналт, тайлан/
- Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, сургалт, арга хэмжээ зохион байгуулах
- Жендэрийн эрх тэгш байдал болон хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа, шинжилгээг салбар бүрээр хийж, олон нийтэд мэдээлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах

Үр дүн:

- ✓ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирна
- ✓ Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн тоо нэмэгдсэн байна
- ✓ Салбар бүрээр хүйсийн тэнцвэртэй байдлын суурь судалгаатай болно

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг зохион байгуулах мэргэжилтэн боловсон хүчнийг чадавхжуулах, хамтын үйл ажиллагааг сайжруулах” 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрийн албан хаагчид болон жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг чадавхжуулах шат дараалсан сургалт арга хэмжээнд хамруулж, мэргэжил арга зүйгээр хангах
- Жендэрийн үндэсний болон орон нутгийн сургагч багшийг бэлтгэх ажлыг зохион байгуулах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах

Үр дүн:

- ✓ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавх бэхэжсэн байна
- ✓ Жендэрийн сургагч багшийн тоо нэмэгдсэн байна
- ✓ Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, хамтарч ажилласан ажил, арга хэмжээний тоо нэмэгдсэн байна

“Жендэрийн талаар олон нийтийн мэдлэг ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах” 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

- ✓ Жендэрийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоо, хүлээх үүрэг

6.1. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хөтөлбөрийн санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

6.2.1. Дэд хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын хэсэг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, салбар дундын уялдаа холбоог нэгтгэн ажиллана.

6.2.2. Сумдын Засаг дарга тухайн сумын нутаг дэвсгэрт дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээллийг жил бүр /жил бүрийн 12 сарын 10-ны дотор/ аймгийн ЗДТГ-т хүргүүлнэ.

6.2.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож хамтран ажиллана.

6.2.4. Төрийн бус байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, хөндлөнгийн үнэлгээ хийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах ажлыг зохион байгуулна.

6.2.5. Хэвлэл мэдээллийн байгууллага нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт


7.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцан ажиллана.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, мэдээллээр хангах, хяналт тавих ажлыг Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран гүйцэтгэнэ.

7.3. Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнгийн талаар тайлан мэдээллийг тухайн ажлыг хариуцсан байгууллага гаргана.

7.4. Хэрэгжилтийг нэгтгэн үр дүнг тооцох, тайлагнах ажлыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцаж, жил бүрийн 12 дугаар сард Аймгийн Засаг даргын Тамгын Хяналт, шинжилгээ, дотоод аудитын хэлтэст болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

----oOo----



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 120 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө /2018-2021/

Зорилго	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, мэргэжлийн боловсон хүчнийг чадваржуулах арга хэмжээг зохион байгуулах замаар олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулан, эрх тэгш оролцоог нэмэгдүүлэн, жендэрт суурилсан аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.			
Үр нөлөө /шалгуур үзүүлэлт/	<ol style="list-style-type: none"> 1. Сумдад жендэрийн 15 салбар хороо байгуулагдаж үйл ажиллагаа нь тогтмолжсон байна 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн тоо 20 хувиар нэмэгдсэн байна 3. 5 салбарт хүйсийн тэнцвэртэй байдлын суурь судалгаатай болсон байна 4. Жендэрийн үндэсний болон орон нутгийн сургагч багшийн тоо 10 дахин нэмэгдсэн байна 5. Олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг ойлголт сайжирсан байна 6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрсэн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдээлэл, сурталчилгаа, нэвтрүүлгийн тоо 30 хувиар нэмэгдсэн байна 7. Хүчирхийллээс хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвтэй болсон байна 8. Шийдвэр гаргах түвшиний эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэн байна. 			
Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны чиглэл	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцлагч, хэрэгжүүлэгч байгууллага
	Бүтээгдэхүүн			Хамтран зохион байгуулагч байгууллага
“Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх, жендэрийн судалгаа, үнэлгээг салбар бүрээр хийх” 1 дүгээр зорилтын хүрээнд				
Сумдын жендэрийн салбар хорооны үйл ажиллагааг нь тогтмолжуулах мэргэжил арга зүйгээр хангах	Бүх сумдад жендэрийн салбар хороо байгуулах	Жендэрийн салбар хороотой болсон сумын тоо	2018-2019	Сумдын ЗДТГ
	Салбар хороодын гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөмж чиглэл хүргүүлэх	Хүргүүлсэн зөвлөмж, арга зүйн зөвлөгөө чиглэлийн тоо	2018-2021	Жендэрийн салбар зөвлөл Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах	Хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын тоо	2018-2021	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, Иргэний нийгмийн байгууллага	Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, Хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ
Төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	Төрийн бус байгууллагаар зарим арга хэмжээг гэрээлэн гүйцэтгүүлэн хамтран ажиллах	Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлсэн арга хэмжээний тоо	2018-2021	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, Иргэний нийгмийн байгууллага	Хэвлэл мэдээллийн байгууллага, Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ
Жендэрийн үндэсний болон орон нутгийн сургагч багшийг бэлтгэх ажлыг зохион байгуулах	Үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх	Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	2018-2021	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, Иргэний нийгмийн байгууллага	Хэвлэл мэдээллийн байгууллага, Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ

“Жендэрийн талаар олон нийтийн мэдлэг ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах” 3 дугаар зорилтын хүрээнд

Олон нийтийн жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг сайжруулах, мэдлэг олгох сургалт арга хэмжээг зохион байгуулах	Жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт арга хэмжээг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүний тоо	2018-2021	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, ГБХЗХГ, НТБТ	Хэвлэл мэдээллийн байгууллага, Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ
	Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан гэр бүл (хүний) тоо	2018-2021	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, ГБХЗХГ, НТБТ	Хэвлэл мэдээллийн байгууллага, Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ
	Ахлах ангийн суралцаад мэргэжил сонголтын чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Мэргэжил сонголт сургалт арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	БСУГ, ГБХЗХГ, НТБТ	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, Сумдын ЗДТГ, Хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ
	Жендэрийн эрх тэгш байдлыг талаарх агуулга бүхий урлагийн бүтээл туурвих, урамшуулах механизмыг бий болгох	Уран бүтээлийн тоо	2018-2021	БСУГ, ХЖТ,	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, Чөлөөт уран бүтээлчид, Хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ
Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн арга хэмжээг зохион байгуулах	Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээнд оролцсон эрэгтэйчүүдийн тоо	2018-2021	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, ГБХЗХГ, НТБТ	Хэвлэл мэдээллийн байгууллага, Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Жендэр болон жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах	Жендэрийн асуудлыг анхаардаг тэмдэг тэмдэглэгээ бий болгож, үйлчилгээний байгууллагуудад нэвтрүүлэх	Хэвлэл мэдээллийн байгууллага, Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ
	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх сургалтаар Жендэрийн талаар мэдлэг ойлголт өгөх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах	Аймгийн жендэрийн салбар зөвлөл, ажлын хэсэг, БСУГ
	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажиллагсад сургалт мэдээлэл зохион байгуулах	Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ
	Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад манлайсан Шилдэг хэвлэл мэдээллийн байгууллагыг шалгаруулах	Сумдын ЗДТГ, Жендэрийн үндэсний зөвлөлийн ажлын алба, ТББ

“Нийгмийн хөгжлөөс эрэгтэй эмэгтэй хүн эрх тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийлээс урьдчилан сэргийлэх” 4 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

Эрэгтэйчүүдэд үйлчлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх	Эрэгтэйчүүдэд үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Эрүүл мэндийн газар, БОЭТ	2018-2021	Аймгийн ЗДТГ, ТББ
	Эрэгтэйчүүдийн кабинетийг тохижуулан үйл ажиллагааг өргөжүүлэх	Эрүүл мэндийн газар, БОЭТ	2018-2021	Аймгийн ЗДТГ, ТББ
	Эрэгтэйчүүдийн кабинетийн эмч, мэргэжилтнийг мэргэшүүлэх сургалтад хамруулах	Эрүүл мэндийн газар, БОЭТ	2018-2021	Аймгийн ЗДТГ, ТББ
	Өрх толгойлон амьдардаг эцэг эх, болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, олон хүүхэдтэй гэр бүлийн амьжиргааг дагшлуулж ажлыг зохион байгуулах	ХХУГ	2018-2021	Сумдын ЗДТГ, ТББ
Жендэрт суурилсан гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Хүчирхийлээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	ГБХЗХГ, БСУГ	2018-2021	Сумдын ЗДТГ, НТБТ, ТББ
	Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, гишүүдийг чадавжуулах	ГБХЗХГ, Цагдаагийн газар	2018-2021	Сумдын ЗДТГ, НТБТ, ТББ

Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байр/нэг цэгийн үйлчилгээ/ байгуулах	Хамгаалах байрын тоо, түүгээр үйлчлүүлэгчдийн тоо	2018-2021	ГБХЗХГ, Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, ТББ
	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо	2018-2021	ГБХЗХГ, Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, хамтарсан баг, ТББ
Шийдвэр гаргах түвшинд хүйсийн харьцааг бий чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Гэр бүлд зөвлөгөө өгөх сэтгэл зүйчдийг бэлтгэх	Мэргэссэн сэтгэл зүйчдийн тоо	2018-2021	ГБХЗХГ, Цагдаагийн газар	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, хамтарсан баг, ТББ
	Гүйцэтгэх шийдвэр гаргах түвшний хүйсийн эрх тэгш оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Шийдвэр гаргах түвшний хүйсийн харьцаа, зохион байгуулсан арга хэмжээний тоо	2018-2021	Нутгийн өөрөө удирдах байгууллага, ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, ТББ
	Шийдвэр гаргахад бэлтгэх зорилгоор эмэгтэйчүүдэд чадавхжуулах сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	2018-2021	Нутгийн өөрөө удирдах байгууллага, ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, ТББ
	Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн мэдээллийн сан бүрдүүлэх, чадавхжуулах сургалт, арга хэмжээнд хамруулах	Сургалтад хамрагдсан шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн тоо	2018-2021	Нутгийн өөрөө удирдах байгууллага, ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, ТББ